



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 03 өдөр

Дугаар A/419

Ховд

┌ Мөнгөн урамшуулал олгох тухай ┐

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, аймгийн Төрийн аудитын газрын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сум, байгууллагын 2019 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангахад амжилт гаргаж нэгдсэн тайлан болон харъяа байгууллагууд нь аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажилласан Жаргалант, Мөнххайрхан сумын Засаг дарга нарыг нэг сарын албан тушаалын цалингийн 30.0 хувиар, Алтай, Булган, Манхан сумын Засаг дарга нарыг нэг сарын албан тушаалын цалингийн 20.0 хувиар тооцож тус, тус мөнгөн урамшуулал олгосугай.

2. Жаргалант, Мөнххайрхан сумдын Санхүүгийн албаны дарга нарыг үндсэн цалингийн 30.0 хувиар, Алтай, Булган, Манхан сумдын Санхүүгийн албаны дарга нарыг үндсэн цалингийн 20.0 хувиар тус, тус тооцож мөнгөн урамшуулал олгохыг тус сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж мөнгөн урамшуулалыг 2020 оны батлагдсан цалингийн санд багтаан олгохыг төсвийн захирагчдад үүрэг болгосугай.

4. Тус захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01840
D/Zah-A/419-Bo